



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160

Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,

Цахим шуудан: info@mddc.gov.mn,

Цахим хуудас: www.mddc.gov.mn

2024. 06. 11 № 01/1217
танай _____-ны № _____-т

Хэрэгжилт хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-д заасны дагуу тус яаманд хамаарах “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт.....хуудастай.



Н.УЧРАЛ

1524066357

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
Цахим хөгжил, харилцаа холбооны яам
2024 оны эхний хагас жилийн биелэлт



Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	ТЭРҮҮЛЭХ ЧИЛГЭЛ 7.ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.	Үнэлгээ
1	7.2. Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ. 7.2.2. Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэнэ.	7.2.2.1. Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдла, сервер төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж өргөтгөх	Гадаад сүлжээний урсгалд үндсэн халдлага, илрүүлэх, эсэргүүцэх чиг үүрэг бүхий систем	Тоо	2	12,700.0 Улсын төсөв	-	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд "Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж өргөтгөх" арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг тусган Монгол Улсын Их Хурлын дарга болон Сангийн намад 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/1634 дугаартай албан бичгээр хүрүүлсэн боловч төсөв батлагдаагүй болно. Иймд уг арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байна.	Үнэлэх боломжгүй
2	7.2. Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ. 7.2.2. Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэнэ.	7.2.2.2. Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв /CERT/ байгуулах	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх байгуулах төв ажлын явц	Хувь	100	7,250.0 Гадаадын зээл	-	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг Цахим хөгжил, харилцаа холбооны намын дэргэд байгуулахаар шийдвэрлэсэн. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ыг Монгол Улсын Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр бүртгүүлж, улсын бүртгэлийн 9068001076 дугаартай гэрчилгээ олгосон. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б/48 дугаар тушаалаар Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирлыг томилсон. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/122 дугаар тушаалаар Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын зохион байгуулалтын нэрийн албан тушаалын нэр, орон тоог баталж, 8 ажилтныг томилж, үйл ажиллагааг эхлүүлээд байна. Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийтай байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" УТҮГ-т шаардлагатай программ хангамж, тавилга, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлын даалгаврыг боловсруулсан. Дэлхийн Банктай хамтран төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг хамтран боловсруулж байна.	100
3	7.2.3. Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна.	7.2.3.1. Интернетийн холболт, аюулгүй байдлыг сайжруулах	Монголын интернетийн дотоод харилцан холболт /МНХ-ын дэд бүтцийн нөөц дэд бүтцийг бий болгох ажлын явц	Хувь	100	4,680.0 Гадаадын зээл	-	Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Ухаалаг засаг-2" төслийн санхүүжилтээр "Интернэтийн харилцан холбоолтын төхөөрөмжийг шинэчлэх, аюулгүй байдлыг сайжруулах" төслийг хэрэгжүүлэхээр ажлын даалгаврыг боловсруулсан. "Интернэтийн харилцан холбоолтын төхөөрөмжийг шинэчлэх, аюулгүй байдлыг сайжруулах" төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг Дэлхийн Банктай хамтран боловсруулж байна.	30

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний
хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт
2024 оны эхний хагас жил



Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2024 оны 08 сарын 11-ны өдрийн 11/Дугаартай
албан бичгийн 2... дугаар хавсралт.

Д/д	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээ
1	7.2.2. Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэнэ.	Төрийн үйлчилгээг цахимаар хүртэгчид	Мянган хүн	2022	1,488	2,000	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.E-Mongolia.mn)-д 2021 онд 59 байгууллагын 606, 2022 онд 69 байгууллагын 897, 2024 оны 05 дугаар сарын сүүлийн байдлаар 86 байгууллагын 1233 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж, нийт 49,794,277 (47,776,602 нь амжилттай) удаагийн хандалт бүртгэгдсэн байна. Тус системээс 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,4 сая хэрэглэгч үйлчилгээ авсан ба 2024 онд 81 мянга орчим хэрэглэгч шинээр нэмэгдэж, 1,817,760 буюу насанд хүрсэн иргэдийн 77% нь бүртгүүлж, 456,992 хэрэглэгч идэвхтэй ашиглаж байна.	90
2	7.2.3. Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна.	Харилцаа холбооны дэд бүтцийн индекс /НҮБ-ын цахим засгийн судалгаа/	Оноо	2022	0.7	0.1	Нэгдсэн Үндэсний байгууллагын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн салбар байгууллагаас "Цахим засаглалын хөгжлийн индекс"-ийг 2 жил тутам шинэчлэн гаргадаг. Монгол Улсын хувьд 2022 онд 193 орноос 92 дугаар байранд байсан бол 18 байраар урагшилж 74 дүгээр байранд орсон. 2023, 2024 оны цахим засаглалын хөгжлийн индексээр дэлхийн 193 орноос ямар түвшинд байгаа эсэх талаарх шинэчилсэн мэдээлэл хараахан гараагүй бөгөөд цахим засгийн судалгааны мэдээллийг бэлтгэн 2023 оны 12 дугаар сард Нэгдсэн Үндэсний байгууллагын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн салбар байгууллагад хүргүүлсэн. Дээрхтэй холбоотой мэдээллийг шууд үзэх болох холбоос https://publicadministration.un.org/egovkb/Data-Center линк.	30



**ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
“УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2024 он**

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
“УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2024.06.10

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан Бодлогын баримт бичиг үнэлэх аргачлалын дагуу шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэв.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2023 оны “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар Монгол Улсын хэмжээнд тэргүүлэх 8 чиглэлийг тодорхойлсон.

Дээрх 8 тэргүүлэх чиглэлийн 7 дахь хэсэгт “Засаглалын үзүүлэлтийг сайжруулах”-аар заасан бөгөөд Цахим хөгжил харилцаа холбооны яамны хувьд 7.2 “Төрийн бүтээмжийг дээшлүүлэх” зорилгын хүрээнд 3 арга хэмжээ тусгасан байна. Үүнд:

1. 7.2.2.1-д “Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж өргөтгөх”
2. 7.2.2.2-т “Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв /CERT/ байгуулах”
3. 7.2.3.1-д “Интернэтийн харилцан холболт, аюулгүй байдлыг сайжруулах” гэж 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд нягтлан үзэхэд сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд “Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж өргөтгөх” ажилд зарцуулах 12,700.0 төгрөгийн хэмжээг тусган Монгол Улсын Их Хурлын дарга болон Сангийн яаманд 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/1634

дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч, төсвийн төсөлд багтаж батлагдаагүйн улмаас уг ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. Иймээс тухайн арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үзсэн болно.

Тодруулбал Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6-д “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг бүх аймаг, нийслэлийг хамруулан хийх ажлыг зохион байгуулна, шаардагдах зардлыг төсөвт тусган батлуулсан байна...” гэж заасан шаардлага биелэгдээгүй байх тул тухайн хэрэгжилтийг цаашид зохион байгуулах боломжгүй гэж үзэж үнэлгээнээс хасаж тооцлоо.

Мөн “Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв /CERT/ байгуулах” арга хэмжээний хувьд 2024 оны төсвийн төсөлд 7,250.0 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч, төсвийн төсөлд багтаж батлагдаагүй байна.

Гэвч Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэд байгуулсан ба Монгол Улсын Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр бүртгүүлж, улсын бүртгэлийн 9068001076 дугаартай гэрчилгээ авсан байна.

Иймээс Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны Б/48 дугаар тушаалаар Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирлыг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/122 дугаар тушаалаар тус газрын зохион байгуулалтын нэгжийн албан тушаалын нэр, орон тоог баталж, 8 ажилтантайгаар үйл ажиллагааг эхлүүлсэн байна.

Улсын төсвийн төсөлд тусгагдаагүй тул Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциатай байгуулсан “Ухаалаг засаг-2” төслийн хүрээнд “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-т шаардлагатай программ хангамж, тавилга, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг хийхээр тогтож, Дэлхийн Банктай хамтран худалдан авах ажиллагааны баримт бичгийг боловсруулж байгаа талаар тайланд дурдсан байх тул төсөл арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн байна үзэж 100 хувиар үнэлгээ хийлээ.

Мөн “Интернэтийн харилцан холболт, аюулгүй байдлыг сайжруулах” арга хэмжээний хувьд дээрх 2 арга хэмжээний адилаар 2024 оны улсын төсөвт 4,680.0 төгрөг зарцуулахаар төлөвлөгөө илгээсэн боловч улсын төсөвт тусгагдаагүй тул Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ухаалаг засаг-2” төслийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төслийн ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг Дэлхийн Банктай хамтран боловсруулж байна гэж тайлагнасан байх тул арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хараахан хүрээгүй байна гэж үзэж 30 хувиар үнэлгээ хийлээ.

Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн 3 арга хэмжээний хэрэгжилтийг нягтлан, цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 арга хэмжээний хүрээнд үнэлгээ хийхэд ерөнхий гүйцэтгэл 65% хувьтай байна.

Дээрхээс гадна Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтэд 2 зорилтот үр дүнг тусгасан байна. Эдгээр нь:

1. 7.2.2. Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэх.

2. 7.2.3 Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах гэсэн 2 зорилтыг дэвшүүлсэн байна.

Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэх ажлын явц сайн буюу Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.E-Mongolia.mn)-д 2021 онд 59 байгууллагын 606, 2022 онд 69 байгууллагын 897, 2024 оны 05 дугаар сарын сүүлийн байдлаар 86 байгууллагын 1233 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж, нийт 49,794,277 (47,776,602 нь амжилттай) удаагийн хандалт бүртгэгдсэн байна. Тус системээс 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,4 сая хэрэглэгч үйлчилгээ авсан ба 2024 онд 81 мянга орчим хэрэглэгч шинээр нэмэгдэж, 1,817,760 буюу насанд хүрсэн иргэдийн 77% нь бүртгүүлж, 456,992 хэрэглэгч идэвхтэй ашиглаж байгаа талаарх тайлан, баримтын хамтаар ирүүлсэн ба эхний хагас жилийн байдлаар дээрх зорилтын хэрэгжилтийн 90 хувьд хүрсэн сайн үзүүлэлт байгааг онцолж байна. Иймээс хэрэгжилтийн тайлагналттай холбоотойгоор тодорхой үр дүнд хүрсэн гэж үзэж 90 хувиар үнэлгээ хийлээ.

Мөн Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах ажлын хувьд Нэгдсэн Үндэсний байгууллагын “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ийг шинэчлэн гаргадаг. Монгол Улсын хувьд 2022 онд 193 орноос 92 дугаар байранд байсан бол 18 байраар урагшилж 74 дүгээр байранд орсон. 2023, 2024 оны цахим засаглалын хөгжлийн индексээр дэлхийн 193 орноос ямар түвшинд байгаа эсэх талаарх шинэчилсэн мэдээлэл хараахан гараагүй бөгөөд цахим засгийн судалгааны мэдээллийг бэлтгэн 2023 оны 12 дугаар сард Нэгдсэн Үндэсний байгууллагын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн салбар байгууллагад хүргүүлсэн нь тухайн ажил ямар шатанд хэрэгжиж байгааг одоогоор мэдэх боломжгүй боловч, дэд бүтцийг сайжруулах ажлын явц тодорхой хэмжээнд урагшилсан болохыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны тайлан болон бусад мэдээ мэдээллээс үзэх боломжтой гэж үзэж байна.

Дээрх ажлын хувьд шалгуур үзүүлэлтээр НҮБ-н цахим засгийн судалгаа гэж тодорхойлсон нь үнэлгээ буурах шалтгаан болсон бөгөөд тухайн ажлын явцын байдал хэрхэн урагшилсан талаарх эцсийн дүнг Нэгдсэн Үндэсний байгууллагын зүгээс бусад улстай харьцуулан гаргасан судалгаанаас дэлгэрэнгүй үзэхээр байх тул 2024 оны эхний хагас жилийн байдлаар судалгааны шийдвэр гараагүй боловч хамаарах тайлан мэдээгээ хүргүүлсэн гэж үзэж 30 хувиар үнэлгээ хийлээ.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах төсөл, арга хэмжээний талаарх төлөвлөлтийг улсын төсвөөс хөрөнгийн эх үүсвэрээ тогтоохоор хүргүүлсэн гэх боловч, улсын төсөв батлагдаагүй шалтгааны талаар тайлан ирүүлээгүй байна.

Мөн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтүүд оновчгүй, хэмжих нэгжийг буруу тодорхойлсон, төсөв шаардагдах ажлын суурь судалгааны баримт байхгүй, тайлагналт дутуу байна.

Тодруулбал төлөвлөгөөний дагуу гарсан үр дүнгийн тайланг ирүүлэх байтал буруу шалгуур үзүүлэлтийн улмаас тайлагналт үр дүнрүү чиглээгүй зөвхөн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнажээ.

Төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүд бүгд төсөвгүйгээр хийгдэх боломжгүй байгаа тул Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хувьд өөр боломж, гарцыг судалж

Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ухаалаг засаг-2” төслийн санхүүжилтэд багтаах зорилго тавин баримт бичгийн шатанд хэрэгжиж байна гэж үзлээ.

Мөн яамны зүгээс илгээгддэг төлөвлөлтийн баримт бичгүүдийн хувьд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлсэн эсэх талаар сайтар хянах шаардлагатай байна.

Иймээс нөхцөл байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг бэлтгэлээ.

Тав.Цаашид авч хэрэгжүүлэх зөвлөмж

1. Төлөвлөлтийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу бэлтгэх;

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу бэлтгэсэн төлөвлөгөөний төслийг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас саналыг авч холбогдох байгууллагад хүргүүлж байх;

3. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг мэргэжилтэн болон нэгжийн удирдлагууд мөрдлөг болгон ажиллах;

4. Төлөвлөгөөний биелэлт нь тухайн байгууллага, нэгж, ажилтан бүрийн хийсэн ажлын үр дүнг харуулдаг тул хугацаа, агуулгыг анхаарах;

5. Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа хүрэх түвшний тоон үзүүлэлтийг болон чанарыг харгалзах;

6. Төлөвлөгөөнд туссан боловч салбарын бусад байгууллагаас хамаарах ажилд анхаарал хандуулж, хамтран ажиллах;

7. Төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтийг тооцоо судалгаатай, баталгаатай хэмжигдэхүйц байдлаар төлөвлөж, санхүүжилт тавигдах эсэхийг урьдчилан тооцож хэвших.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй болно.



**ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
“УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2024 он**

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
“УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2024.06.10

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан Бодлогын баримт бичиг үнэлэх аргачлалын дагуу шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэв.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2023 оны “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар Монгол Улсын хэмжээнд тэргүүлэх 8 чиглэлийг тодорхойлсон.

Дээрх 8 тэргүүлэх чиглэлийн 7 дахь хэсэгт “Засаглалын үзүүлэлтийг сайжруулах”-аар заасан бөгөөд Цахим хөгжил харилцаа холбооны яамны хувьд 7.2 “Төрийн бүтээмжийг дээшлүүлэх” зорилгын хүрээнд 3 арга хэмжээ тусгасан байна. Үүнд:

1. 7.2.2.1-д “Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж өргөтгөх”
2. 7.2.2.2-т “Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв /CERT/ байгуулах”
3. 7.2.3.1-д “Интернэтийн харилцан холболт, аюулгүй байдлыг сайжруулах” гэж 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд нягтлан үзэхэд сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд “Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж өргөтгөх” ажилд зарцуулах 12,700.0 төгрөгийн хэмжээг тусган Монгол Улсын Их Хурлын дарга болон Сангийн яаманд 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/1634

дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч, төсвийн төсөлд багтаж батлагдаагүйн улмаас уг ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. Иймээс тухайн арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үзсэн болно.

Тодруулбал Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6-д “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг бүх аймаг, нийслэлийг хамруулан хийх ажлыг зохион байгуулна, шаардагдах зардлыг төсөвт тусган батлуулсан байна...” гэж заасан шаардлага биелэгдээгүй байх тул тухайн хэрэгжилтийг цаашид зохион байгуулах боломжгүй гэж үзэж үнэлгээнээс хасаж тооцлоо.

Мөн “Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв /CERT/ байгуулах” арга хэмжээний хувьд 2024 оны төсвийн төсөлд 7,250.0 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч, төсвийн төсөлд багтаж батлагдаагүй байна.

Гэвч Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэд байгуулсан ба Монгол Улсын Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр бүртгүүлж, улсын бүртгэлийн 9068001076 дугаартай гэрчилгээ авсан байна.

Иймээс Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны Б/48 дугаар тушаалаар Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирлыг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/122 дугаар тушаалаар тус газрын зохион байгуулалтын нэгжийн албан тушаалын нэр, орон тоог баталж, 8 ажилтантайгаар үйл ажиллагааг эхлүүлсэн байна.

Улсын төсвийн төсөлд тусгагдаагүй тул Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциатай байгуулсан “Ухаалаг засаг-2” төслийн хүрээнд “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-т шаардлагатай программ хангамж, тавилга, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг хийхээр тогтож, Дэлхийн Банктай хамтран худалдан авах ажиллагааны баримт бичгийг боловсруулж байгаа талаар тайланд дурдсан байх тул төсөл арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн байна үзэж 100 хувиар үнэлгээ хийлээ.

Мөн “Интернэтийн харилцан холболт, аюулгүй байдлыг сайжруулах” арга хэмжээний хувьд дээрх 2 арга хэмжээний адилаар 2024 оны улсын төсөвт 4,680.0 төгрөг зарцуулахаар төлөвлөгөө илгээсэн боловч улсын төсөвт тусгагдаагүй тул Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ухаалаг засаг-2” төслийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төслийн ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг Дэлхийн Банктай хамтран боловсруулж байна гэж тайлагнасан байх тул арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хараахан хүрээгүй байна гэж үзэж 30 хувиар үнэлгээ хийлээ.

Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн 3 арга хэмжээний хэрэгжилтийг нягтлан, цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 арга хэмжээний хүрээнд үнэлгээ хийхэд ерөнхий гүйцэтгэл 65% хувьтай байна.

Дээрхээс гадна Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтэд 2 зорилтот үр дүнг тусгасан байна. Эдгээр нь:

1. 7.2.2. Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэх.

2. 7.2.3 Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах гэсэн 2 зорилтыг дэвшүүлсэн байна.

Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэх ажлын явц сайн буюу Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.E-Mongolia.mn)-д 2021 онд 59 байгууллагын 606, 2022 онд 69 байгууллагын 897, 2024 оны 05 дугаар сарын сүүлийн байдлаар 86 байгууллагын 1233 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж, нийт 49,794,277 (47,776,602 нь амжилттай) удаагийн хандалт бүртгэгдсэн байна. Тус системээс 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,4 сая хэрэглэгч үйлчилгээ авсан ба 2024 онд 81 мянга орчим хэрэглэгч шинээр нэмэгдэж, 1,817,760 буюу насанд хүрсэн иргэдийн 77% нь бүртгүүлж, 456,992 хэрэглэгч идэвхтэй ашиглаж байгаа талаарх тайлан, баримтын хамтаар ирүүлсэн ба эхний хагас жилийн байдлаар дээрх зорилтын хэрэгжилтийн 90 хувьд хүрсэн сайн үзүүлэлт байгааг онцолж байна. Иймээс хэрэгжилтийн тайлагналттай холбоотойгоор тодорхой үр дүнд хүрсэн гэж үзэж 90 хувиар үнэлгээ хийлээ.

Мөн Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах ажлын хувьд Нэгдсэн Үндэсний байгууллагын “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ийг шинэчлэн гаргадаг. Монгол Улсын хувьд 2022 онд 193 орноос 92 дугаар байранд байсан бол 18 байраар урагшилж 74 дүгээр байранд орсон. 2023, 2024 оны цахим засаглалын хөгжлийн индексээр дэлхийн 193 орноос ямар түвшинд байгаа эсэх талаарх шинэчилсэн мэдээлэл хараахан гараагүй бөгөөд цахим засгийн судалгааны мэдээллийг бэлтгэн 2023 оны 12 дугаар сард Нэгдсэн Үндэсний байгууллагын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн салбар байгууллагад хүргүүлсэн нь тухайн ажил ямар шатанд хэрэгжиж байгааг одоогоор мэдэх боломжгүй боловч, дэд бүтцийг сайжруулах ажлын явц тодорхой хэмжээнд урагшилсан болохыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны тайлан болон бусад мэдээ мэдээллээс үзэх боломжтой гэж үзэж байна.

Дээрх ажлын хувьд шалгуур үзүүлэлтээр НҮБ-н цахим засгийн судалгаа гэж тодорхойлсон нь үнэлгээ буурах шалтгаан болсон бөгөөд тухайн ажлын явцын байдал хэрхэн урагшилсан талаарх эцсийн дүнг Нэгдсэн Үндэсний байгууллагын зүгээс бусад улстай харьцуулан гаргасан судалгаанаас дэлгэрэнгүй үзэхээр байх тул 2024 оны эхний хагас жилийн байдлаар судалгааны шийдвэр гараагүй боловч хамаарах тайлан мэдээгээ хүргүүлсэн гэж үзэж 30 хувиар үнэлгээ хийлээ.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах төсөл, арга хэмжээний талаарх төлөвлөлтийг улсын төсвөөс хөрөнгийн эх үүсвэрээ тогтоохоор хүргүүлсэн гэх боловч, улсын төсөв батлагдаагүй шалтгааны талаар тайлан ирүүлээгүй байна.

Мөн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтүүд оновчгүй, хэмжих нэгжийг буруу тодорхойлсон, төсөв шаардагдах ажлын суурь судалгааны баримт байхгүй, тайлагналт дутуу байна.

Тодруулбал төлөвлөгөөний дагуу гарсан үр дүнгийн тайланг ирүүлэх байтал буруу шалгуур үзүүлэлтийн улмаас тайлагналт үр дүнрүү чиглээгүй зөвхөн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнажээ.

Төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүд бүгд төсөвгүйгээр хийгдэх боломжгүй байгаа тул Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хувьд өөр боломж, гарцыг судалж

Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ухаалаг засаг-2” төслийн санхүүжилтэд багтаах зорилго тавин баримт бичгийн шатанд хэрэгжиж байна гэж үзлээ.

Мөн яамны зүгээс илгээгддэг төлөвлөлтийн баримт бичгүүдийн хувьд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлсэн эсэх талаар сайтар хянах шаардлагатай байна.

Иймээс нөхцөл байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг бэлтгэлээ.

Тав.Цаашид авч хэрэгжүүлэх зөвлөмж

1. Төлөвлөлтийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу бэлтгэх;

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу бэлтгэсэн төлөвлөгөөний төслийг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас саналыг авч холбогдох байгууллагад хүргүүлж байх;

3. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг мэргэжилтэн болон нэгжийн удирдлагууд мөрдлөг болгон ажиллах;

4. Төлөвлөгөөний биелэлт нь тухайн байгууллага, нэгж, ажилтан бүрийн хийсэн ажлын үр дүнг харуулдаг тул хугацаа, агуулгыг анхаарах;

5. Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа хүрэх түвшний тоон үзүүлэлтийг болон чанарыг харгалзах;

6. Төлөвлөгөөнд туссан боловч салбарын бусад байгууллагаас хамаарах ажилд анхаарал хандуулж, хамтран ажиллах;

7. Төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтийг тооцоо судалгаатай, баталгаатай хэмжигдэхүйц байдлаар төлөвлөж, санхүүжилт тавигдах эсэхийг урьдчилан тооцож хэвших.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй болно.



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn,
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.08.15. № 01/1634
танай _____-ны № _____-т


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА,
САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН
ТАНАА

Төсвийн төсөл хүргүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл "Төсвийн цагалбар", 27 дугаар зүйл "Төсвийн төсөлд тавигдах шаардлага", 31 дүгээр зүйл "Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл" болон бусад холбогдох хууль эрх зүйн үндэслэлийн дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг боловсруулан хүргүүлж байна.

Хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хавсралтаар танилцуулга, тооцоолол 117 хуудастай.



		Сагсай сум/				сайжруулах						
6	Хөвсгөл	Мөрөн сум	Үүрэн холбооны 4С сүлжээ /Хөвсгөл/	Дэд бүтэц	Инженерийн шугам сүлжээ	м2	Өндөр хурдны интернэтийн үйлчилгээ	I. Барилга байгууламж	2024	2025	600.00	600.00
7	Хэнтий	Норовлин, Баян-Овоо, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дэлгэрхаан сум	Үүрэн холбооны сүлжээ /Норовлин, Баян-Овоо, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дэлгэрхаан сум/	Дэд бүтэц	Инженерийн шугам сүлжээ	км	Шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, хурдыг сайжруулах	I. Барилга байгууламж	2024	2024	1,924.65	1,924.65
8	Увс	Түргэн сум	Харилцаа холбооны дахин дамжуулах станц /Увс, Түргэн сум/	Дэд бүтэц	Инженерийн шугам сүлжээ	км	Шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, хурдыг сайжруулах	I. Барилга байгууламж	2024	2024	226.28	226.28

ШИНЭЭР ХЭРЭГЖИХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

НИЙТ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

III. Тоног төхөөрөмж

9	Улаанбаатар	Сонгинохайрхан	Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулж, өргөтгөх	Төрийн үйлчилгээ, бусад	Аюулгүй байдал	ширхэг	Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулж, өргөтгөх	III. Тоног төхөөрөмж	2024	2024	12,700.00	12,700.00
10	Улаанбаатар	Баянзүрх	Хэт богино долгионы ДАВ+ тоон радио сүлжээ байгуулах	Төрийн үйлчилгээ, бусад	Тоног төхөөрөмж	ширхэг	Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулах	III. Тоног төхөөрөмж	2024	2024	842.30	842.30
11	Улаанбаатар	Баянзүрх	Радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах	Төрийн үйлчилгээ, бусад	Тоног төхөөрөмж	ширхэг	Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах	III. Тоног төхөөрөмж	2024	2024	79,100.00	79,100.00



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

**“Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн
төв” улсын төсөвт үйлдвэрийн газар
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.4, 22.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэд байгуулж, дүрмийг 1 дүгээр хавсралт, Зохион байгуулалтын бүтцийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 52 байхаар тогтоосугай.

3. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрыг улсын бүртгэлд бүртгүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.

4. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2023 оны үйл ажиллагааны зардлыг батлагдсан төсвийн багцдаа багтаан зохицуулалт хийх замаар, 2024 оноос эхлэн улсын төсвийн төсөлд тусган санхүүжүүлж байхыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД

Н.УЧРАЛ

Засгийн газрын 2023 оны 08 дугаар
сарын 30 -ны өдрийн 319 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

“КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв”-ийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, зохион байгуулалтыг тогтоож, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.“Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” (цаашид “Нийтийн төв” гэх) нь хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг улсын төсөвт үйлдвэрийн газар мөн.

1.3.Нийтийн төв нь үйл ажиллагаандаа Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Харилцаа холбооны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг баримтлан ажиллана.

1.4.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Нийтийн төвийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.5.Оноосон бүтэн нэр нь “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар байх бөгөөд товчилсон нэр нь “Нийтийн төв” УТУГ, Англи нэр нь “Public CSIRT/CC” байна.

1.6.“Нийтийн төв” нь холбогдох журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, албаны цахим хаяг, хуудсыг хэрэглэнэ.

Хоёр.Нийтийн төвийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл

2.1.Нийтийн төв нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 21.2.2-т зааснаас бусад иргэн, хуулийн этгээд (цаашид “иргэн, хуулийн этгээд” гэх)-ийн мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер халдлага, зөрчилд өртсөн дэд бүтэц, мэдээллийн системийг нөхөн сэргээхэд мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий хүний нөөц, техник, технологийн чадавх, мэдээллийн сантай байна.

2.2.Нийтийн төв нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 22.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг явуулна:

2.2.1.иргэн, хуулийн этгээд, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хувийн хэвшлийн байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний аюулгүй байдалд зөвлөмж өгөх;

2.2.2.иргэн, хуулийн этгээдээс кибер халдлага, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах, шалгаж шийдвэрлэх;

2.2.3.мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайланг хүлээн авч, зөвлөмж, шаардлага хүргүүлэх;

2.2.4.кибер халдлага, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, Кибер аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах;

2.2.5.кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах;

2.2.6.иргэд, олон нийтэд кибер аюулгүй байдлыг хангах талаар мэдээлэл, сурталчилгааг түгээх;

2.2.7.шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх;

2.2.8.хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн шинэ дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

Гурав.Нийтийн төвийн удирдлага, зохион байгуулалт

3.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Нийтийн төвийн захирлыг томилж, чөлөөлнө.

3.2.Нийтийн төвийн захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

3.3.Захирал нь холбогдох хууль тогтоомж, энэ дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд Нийтийн төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

3.4.Захирал нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Кибер аюулгүй байдлын зөвлөл, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

3.4.2.нийтийн төвийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.4.3.нийтийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн болон эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны найдвартай байдлыг хангах, технологийн горим, хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлэх;

3.4.4.Монгол Улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагатай эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах;

3.4.5.байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн маркетинг, менежментийн үр ашигтай, оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

3.4.6.батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах, тайлагнах, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд тавих дотоод хяналтыг зохион байгуулж, үр дүнг хариуцах;

3.4.7.ажил, үүргээ гүйцэтгэх явцад олж авсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9, 10 дугаар зүйлд заасан мэдээлэл, хуулийн этгээдийн нууцад хамаарах болон хүний хувийн мэдээллийг хуулийн дагуу хадгалах, холбогдох журмын дагуу ажилтантай нууцлалын гэрээ байгуулах;

3.4.8.батлагдсан бүтэц, орон тоонд багтаан Нийтийн төвийн ажилтныг томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, урамшуулал олгох, хариуцлага тооцох;

3.4.9.дотоод үйл ажиллагаа, аюулгүй байдлын бодлого, журам, кибер халдлага, зөрчлийн үед дагаж мөрдөх төлөвлөгөө батлах;

3.4.10.өөрт олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, Нийтийн төвийг гадаад, дотоодод төлөөлөх;

3.4.11.үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх;

3.4.12.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, түүнийг дагаж гарсан нийтлэг журмыг байгууллагын үйл ажиллагаанд чанд мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

4.4.13.хууль тогтоомжид заасан бусад.

3.5.Захирал нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ажлаа улирал тутамд тайлагнана.

3.6.Захирал нь албан үүргээ гүйцэтгэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрмийг мөрдөж ажиллана.

3.7.Захирал нь хууль тогтоомж, дүрмийг зөрчсөн, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь түүнд хариуцлага тооцох үндэслэл болно.

3.8.Захирал нь хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад байгууллагад аливаа албан тушаал, ажил үүрэг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

Дөрөв.Санхүүгийн тайлан, тэнцэл, бүртгэл

4.1.Нийтийн төвийн орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

4.1.1.улсын төсвийн санхүүжилт;

4.1.2.олон улсын байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олох үйлчилгээний орлого;

4.1.3.эрхлэх чиг үүргийн хүрээнд үзүүлсэн өөрийн үйл ажиллагааны орлого;

4.1.4.хууль тогтоомжоор хориглоогүй бусад.

4.2.Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу улирал, жилийн санхүүгийн тайланг гаргаж, аудитаар баталгаажуулан төсвийн ерөнхийлөн захирагч, Үндэсний аудитын газарт тайлагнана.

4.3.Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг захирал, ерөнхий нягтлан бодогч хариуцах бөгөөд санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

4.3.1.баланс;

4.3.2.үйл ажиллагааны орлого, үр дүнгийн тайлан;

4.3.3.мөнгөн гүйлгээний тайлан;

4.3.4.өмчийн өөрчлөлтийн тайлан;

4.3.5.төсвийн жилд хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал, урамшуулал;

4.3.6.бусдаас авах авлага, тэдгээрийн үүссэн шалтгаан, авлага барагдуулалтын явц;

4.3.7.санхүүгийн тайлангийн тодруулга;

4.3.8.нэмэлт тайлбар;

4.3.9.бусад.

4.4.Захирал нь тухайн жилийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтэц, хөрөнгө, санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан дараах мэдээллийг агуулсан тайлан, илтгэх бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ:

4.4.1.тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй танилцуулга, гарсан өөрчлөлт болон эдгээр үйл ажиллагааны үр дүн;

4.4.2.тайлангийн хугацаанд Нийтийн төвийн албан тушаалтан ажилчдад олгосон шагнал, урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ;

4.4.3.шаардлагатай бусад мэдээлэл.

4.5.Төсвийн орлого, зарлагын мэдээ, мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн гүйцэтгэлийн тайланг улирал, жил тутам гаргаж аудитаар баталгаажуулна.

4.6.Эд хөрөнгийн дотоодын тооллогыг хугацаанд нь явуулж, жилийн тайлан, тэнцэлд тусгана.

4.7.Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, нийтэд нээлттэй байхаар заасан мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

Тав.Бусад

5.1.Энэ дүрэмд зааснаас бусад асуудлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.


5.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгах, эсхүл өөрчлөн зохион байгуулна.

5.3.Дүрэмд хуульд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

----o0o----

Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт


**“КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ” УТУГ-ЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ**



И-МОНГОЛ АКАДЕМИ

СИСТЕМ НЭГТГЭЛИЙН ГАЗАР
05.16 – 05.22 хооронд хийгдсэн
ажлын тайлан

2024.05.24



ҮНДСЭН БОЛОН ДЭМЖИХ СИСТЕМҮҮД


18 дугаар зүйл. Нийтийн мэдээллийн дэд бүтэц

18.3. Үндсэн систем нь суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийг төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд ашиглах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн төрийн мэдээлэл солилцооны систем байна.

18.4. Дэмжих систем нь үндсэн болон мэдээлэл хариуцагчийн системийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах зорилго бүхий бие даасан мэдээллийн систем байна.

18.5. Дэмжих системд дараах систем хамаарна:

- танилт, нэвтрэлтийн систем;
- нийтийн түлхүүрийн дэд бүтэц;
- албан бичиг солилцооны дундын систем;
- мэдээлэл солилцооны бүртгэлийн систем;
- мэдэгдэл хүргэх систем;
- төрийн үйлчилгээний нэгдсэн систем;
- төлбөр тооцооны систем;
- хуульд заасан бусад;
- Засгийн газраас шаардлагатай гэж үзсэн бусад систем.



Системтэй холбогдож мэдээлэл авч ашиглаж буй байгууллага		
504		
Төр	Хувийн хэвшил	
145	359	
Сервисийн тоо		
734		
Нийт сервис дамжуулсан тоо	Амжилттай дамжуулсан	
2,757,295,613	2,601,667,600	

Мэдээлэл дамжуулсан тоо			
2024 он нийт		542,634,967	
05 сар		Өнгөрсөн 7 хоногт	
нийт	91,432,395	нийт	27,186,132
амжилттай	86,735,240	амжилттай	25,702,537
амжилттай %	94.8%	амжилттай %	94.5%

№	Шинээр орсон мэдээлэл дамжуулах сервис	Тайлбар
1	WS100251_getPropertyInfoEng	Иргэний эд хөрөнгийн англи лавлагааг авах сервис
2	WS100252_getPropertyInfoByNationalIdentifierEng	Иргэний эд хөрөнгийн англи лавлагааг эд хөрөнгийн дугаараар дуудах сервис
3	WS300165_getEcareByRegnum	Халамжийн бүртгэлийн мэдээллийг лавлах сервис
4	WS300166_getChildrenBirthInfo	Төрсөн хүүхдийн мэдээлэл татах сервис

№	Мэдээлэл дамжуулсан ТОП 10 сервис	2024 онд
1	Иргэний үнэмлэхний мэдээлэл дамжуулах сервис	7,179,730
2	Тээврийн хэрэгслийн өмчлөгч эзэмшигчийн мэдээлэл дамжуулах сервис	2,857,719
3	Эрүүл мэндийн даатгал шимтгэл төлөлт шалгах сервис	1,768,740
4	Оюутны цахим карт	1,371,295
5	Байгууллагын тухайн веб сервисд хандах эрхийг шалгах сервис	1,362,419
6	Тээврийн хэрэгслийн торгуулийн мэдээлэл дамжуулах сервис	1,351,561
7	Тээврийн хэрэгслийн оншилгооны мэдээлэл шалгах сервис	909,771
8	Иргэний нийгмийн даатгалын мэдээлэл дамжуулах сервис	704,620
9	Тээврийн хэрэгслийн төлсөн нэхэмжлэлийн түүхийг харах	588,902
10	Жолоочийн эрхийн мэдээлэл авах	576,592

№	Өөрчлөлт орсон мэдээлэл дамжуулах сервис
1	WS300123_getServiceHistory
2	WS100842_orgenizationLoanInfoTitan
3	WS100843_personLoanInfoTitan
4	WS101145_CitizenNewDiplomaInfo
5	WS100126_getCitizenNonPaymentInfo

1.8 сая хэрэглэгч

86 байгууллагын

1233 үйлчилгээ

47 сая удаагийн үйлчилгээ

Үйлчилгээ	
1 шатлалт	2 шатлалт
209	1,024

ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД | ТОЙМ

Зардал хэмнэлт	2020	2021	2022	2023	2024	Нийт
Иргэн төрийн үйлчилгээ авахдаа үйлчилгээ үзүүлэгч байгууллага руу ирж, буцах үйл ажиллагаа /унаа/-ны зардал	272,277,316	7,658,097,412	18,203,005,622	21,883,367,714	11,331,590,837	59,348,338,901
Иргэн төрийн үйлчилгээ авахдаа зарцуулж буй хугацаанаас үүдэлтэй зардал	4,541,528,560	114,470,813,333	280,110,616,898	327,518,415,720	169,594,768,365	896,236,142,876
Бичиг цаасны зардал	24,851,200	591,395,200	1,287,906,400	1,548,300,864	801,737,288	4,254,190,952
Нийт	4,838,657,076	122,720,305,945	299,601,528,921	350,950,084,298	181,728,096,490	959,838,672,729

Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ нь үндсэн 6 сувагтай болсон.

№	Сувгийн нэр	Үйлчилгээ үзүүлэгч байгууллага тоо	Үйлчилгээний тоо	Үйлчилгээ авч байгаа хувь
1	e-mongolia.mn (иргэн)	86	1233	13%
2	e-business.mn (хуулийн этгээд)	68	760	
3	lavlaaa.e-mongolia.mn (үйлчилгээ үзүүлэгч байгууллагад)	23	81	
4	operator.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ)	39	448	2%
5	kiosk.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ)	12	65	
6	Мобайл аппликейшн	23	151	85%

2024 оны 05 сарын 22-ны байдлаар:

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ХЭРЭГЛЭГЧ:



1,817,760

Энэ нь Монгол улсын хэмжээнд байгаа
насанд хүрсэн иргэдийн 77% болж байна.

⊕ ШИНЭ ХЭРЭГЛЭГЧ

05 сард Өнгөрсөн 7 хоногт

17,627 4,660

ИДЭВХТЭЙ ХЭРЭГЛЭГЧ

05 сард Өнгөрсөн 7 хоногт


456,992 202,670

7 хоногоор гаргасан тоон үзүүлэлтүүд:


7 Хоногууд	04.18-04.24	04.25-05.01	05.02-05.08	05.09-05.15	05.16-05.22
Бүртгэлтэй хэрэглэгч	1,800,133	1,804,302	1,809,075	1,813,096	1,817,760
Шинэ хэрэглэгчийн өсөлт	+4,006*	+4,169*	+4,773*	+4,021*	+4,660*
Идэвхтэй хэрэглэгч	182,779*	189,090*	200,982*	205,463*	202,670*
Идэвхтэй хэрэглэгчийн бүртгэлтэй хэрэглэгчид эзлэх хувь	10,2%	10,4%	11,1%	11,3%	11,1%

7 хоногт дунджаар 4К хэрэглэгч нэмэгдэж байна.

БҮРТГЭЛТЭЙ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО /2023, 2024 оны сараар/ :




ИДЭВХТЭЙ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО /2023, 2024 оны сараар/ :



2024 оны 05 сарын 24-ний байдлаар:

Өдөр	И Кидс бүртгүүлсэн хүүхдийн тоо	И Кидс нэвтэрч ашигласан хүүхдийн тоо
2023.10.16-2024.01.03	16,413	24,036
2024.01.04-2024.02.02	2,500	4,582
2024.02.03-2024.03.01	910	1,883
2024.03.02-2024.04.03	1,403	2,883
2024.04.04-2024.04.17	688	1,301
2024.04.18-2024.05.24	1,409	2,807
Нийт	23,323	37,492



ТОП 20 ҮЙЛЧИЛГЭЭ /2020.10.01 – 2024.05.15/

1	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	11,058,202
2	Иргэний үнэмлэхийн лавлагаа	3,691,456
3	Вакцины гэрчилгээ	3,100,714
4	Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа	3,038,663
5	Зээлийн мэдээллийн лавлагаа (Иргэн)	2,539,520
6	Авто тээврийн хэрэгслийн торгуулийн мэдээлэл	2,510,936
7	Жолоочийн лавлагаа, мэдээлэл	2,423,458
8	Эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах	1,816,967
9	Жолоодох эрхийн оноо	1,710,116
10	Үл хөдлөх эд хөрөнгөтэй эсэх лавлагаа	1,399,708
11	Шинжилгээний хариу авах	1,182,984
12	Гэрлэсний бүртгэлийн лавлагаа	844,131
13	Үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа болон шилжүүлсэн тухай лавлагаа	824,582
14	Эмнэлэгт цаг авах	795,796
15	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт (англи)	756,546
16	Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа	747,817
17	Төрсний бүртгэлийн лавлагаа	616,062
18	Гэрлэсний бүртгэлгүй лавлагаа	550,128
19	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	447,786
20	Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (Иргэн)	389,952

ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД | ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

7 хоногийн ТОП 10 үйлчилгээ:

№	Үйлчилгээний нэр	04.18 – 04.24	04.25 – 05.01	05.02 – 05.08	05.09 – 05.15	05.16 – 05.22
1	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	69,284	90,122	114,137	99,934	108,910
2	Иргэний үнэмлэхийн лавлагаа	35,218	49,552	47,087	46,634	57,671
3	Шинжилгээний хариу авах	22,747	29,318	30,993	30,091	35,323
4	Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа	22,240	28,628	27,483	26,335	30,170
5	Авто тээврийн хэрэгслийн торгуулийн мэдээлэл	22,178	22,267	26,562	25,009	28,522
6	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт (Англи)	15,472	19,660	24,429	20,939	21,677
7	Зээлийн мэдээллийн лавлагаа	12,623	17,065	22,788	19,102	20,348
8	Жолоочийн лавлагаа, мэдээлэл	10,186	13,709	16,746	18,915	18,196
9	Эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах	10,039	11,985	13,891	13,205	14,531
10	Эмнэлэгт цаг захиалах	9,502	11,638	11,892	9,093	12,397




МЭДЭГДЭЛ ХҮРГЭХ СИСТЕМ

| ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НИЙТ ХҮРГЭСЭН МЭДЭГДЭЛ /иргэний мэдээлэлд хандсан тухай хур-аас сервис дуудсан үед/			05 сар		Өнгөрсөн 7 хоногт	
Нийт	28,974,926	Нийт	Нийт	Нийт	Нийт	Нийт
Push Notification	8,908,164	30.7%	Push Notification	0	Push Notification	0
Үндэсний и-мэйл	19,624,476	67.7%	Үндэсний и-мэйл	162,344	Үндэсний и-мэйл	54,900
Хувийн и-мэйл	442,286	1.6%	Хувийн и-мэйл	0	Хувийн и-мэйл	0

/2024 оны 05 сарын 24-ний байдлаар/

Мэдэгдэл илгээсэн байдал /2022, 2023, 2024 оны сараар/:




Иргэний мэдээлэлд хандсан тухай мэдэгдэл



Сүүлийн 30 хоногийн хугацаанд:

ИДЭВХТЭЙ ХЭРЭГЛЭГЧ	
Нийт хандалт	Давхардаагүй хэрэглэгчийн тоо
6.23 сая	35,280



ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД I

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ	
Нийт Үйлчилгээний тоо	Үйлчилгээ авсан тоо
760	142,414

Хуулийн этгээдийн үйлчилгээ	Үйлчилгээ авсан тоо
Нэр баталгаажуулах	57,711
Шинээр ХХК бүртгүүлэх	1,825

СИСТЕМ НЭГТГЭЛИЙН ГАЗАР

| ГЭМТЭЛ СААТАЛ

НИЙТ ГЭМТЭЛ СААТАЛ						
Байршил	Нэр	Огноо	Эхэлсэн	Дууссан	Үргэлжилсэн хугацаа	Шалтгаан
Монгол шуудан	Бүх системүүд	2023.09.27	22:11	22:46	35 минут	Улаанбаатар хот дахь Мэдээлэл холбооны сүлжээ ХК-ийн төв сүлжээний зангилааны MIX төхөөрөмж өнцгдөр шөнө цахилгааны саатлаас болж гэмтсэн.
Үндэсний дата төв	Е- Mongolia системийн бүх сүвгүүд	2023.11.03	08:04	10:03	119 минут	
		2023.11.07	14:53	15:21	28 минут	
		2023.11.13	12:04	12:39	35 минут	
			16:50	18:12	82 минут	
		2023.11.15	17:38	23:43	365 минут	Үндэсний дата төвийн дэд бүтцийн асуудлаас үүсэн системд доголдол үүсэн. Хэвийн болсны дараа дахин нийт серверүүдийн тохиргоог шинээр хийж хэвийн байдалд оруулсан.
		2023.11.16	21:19	23:31	132 минут	
		2023.11.25	12:03	02:51	168 минут	
		2023.11.30	15:54	16:17	23 минут	
		2023.12.07	09:31	09:44	13 минут	
		2023.12.08	20:51	23:59	188 минут	
		2023.12.09	00:00	01:19	79 минут	
Гадаадын иргэн харьяатын газар	Бүх системүүд	2023.12.14	15:00	17:30	150 минут	Гадаадын иргэн харьяатын газрын систем унаж тус байгууллагаас сэргээх процесс удаан үргэлжилсэн тул ҮДТ-н ДАН системээр e-mongolia төдийгүй бусад систем рүү нэвтэрч болохгүй байсан.
Үндэсний дата төв	Бүх системүүд	2023.12.21	22:51	23:11	12 минут	Үндэсний дата төв ҮТҮГ-г аюулгүй байдлын төхөөрөмж сольж сайжруулсан төлөвлөгөөт ажил хийсэн.
Үндэсний дата төв	Бүх системүүд	2024.05.01	10:16	11:18	62 минут	-

2023 оны 06 сарын 28 - 2024 оны 05 сарын 08 хооронд 18 гэмтэл саатал гарсан байна.

	Байгууллагын нэр	Иргэн- 71	Аж ахуй нэгж- 15	Төлбөрийн ангилал
		86		
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	18	6	
2	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар	5	-	
3	Эрүүл мэндийн ДЕГ	3	-	
4	Гаалийн ерөнхий газар	3	2	
5	Боловсролын үнэлгээний төв	4	-	
6	Цагдаагийн ерөнхий газар	7	2	Төлбөртэй - 6
7	Нийгмийн даатгалын ерөнхий газар	7	1	Төлбөргүй - 79
8	Газрын алба	9	0	
9	Татварын ерөнхий газар	1	4	
10	Монголын Нотариатчдын танхим	5	-	
11	Авто тээврийн үндэсний төв	3	-	
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	1	-	
13	Эрүүл мэндийн яам	4	-	
14	Сайн скор	1	-	
15	Албан хэрэгцээнд/ЦЕГ,АТГ,ТЕГ/	2	2	


СИСТЕМИЙН АШИГЛАЛТ ТООН МЭДЭЭЛЛҮД

	Бүртгэлтэй байгууллага	тоо
1	Хэрэглэгч байгууллагын тоо	38
2	Лавлагааны тоон мэдээлэл	720.687
3	Төлбөртэй лавлагаа авсан тоо	4.067
4	Систем хэрэглэгчийн тоон мэдээлэл/Ажилтан/	7.437

	Бүртгэлтэй байгууллага	тоо
1	Арилжааны банк	11
2	Банк бус санхүүгийн байгууллага	5
3	Үүрэн холбооны оператор	2
4	Төрийн байгууллага	16
5	Даатгалын байгууллага	1
6	Зээлийн мэдээллийн сан	1

ERP систем хэрэглэгчид тоон үзүүлэлтүүд


ERP системтэй холбогдсон байгууллагуудаас оржирсэн асуудал шийдвэрлэлтийн тоон мэдээлэл



ERP цахим харилцааны модуль/ ERP E-chat / нь 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэглээнд нэвтэрсэн бөгөөд одоогийн байдлаар андرويد утасны 11,800 хэрэглэгч, ios 40,200 хэрэглэгч нийт 52,000 хэрэглэгч албан харилцаандаа хэрэглэж байна.

Opendata.gov.mn /Нээлттэй өгөгдлийн тоон үзүүлэлтүүд/

Судалгааны тоон мэдээлэл:



Нийт холбогдсон төрийн байгууллагын тоо:	Нийт судалгаа
84	1403



АЛБАН БИЧИГ СОЛИЛЦООНЫ
ДУНДЫН СИСТЕМ

Dosx.gov.mn

	Системийн нэр
1	Ework.hudumug-halamj.gov.mn/Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар
2	Erg.e-mongolia.mn /Төрийн байгууллагын нэгдсэн систем/
3	Able.mn/Эйблсофт ХХК/
4	Engui Sign/Энгүй шийдэл/
5	Edoc.mn
6	Digital.gov.mn/Veritech систем/ЗГХЭГ
7	Прокурорын ERP систем
8	Eoffice.tpp4.mn
9	www.uia.able.mn
10	iMCAA
11	Veritech MFA
12	Smartoffice
13	Veritech /Барилга хөгжлийн төв/
14	Dandaа.mn /Дархан-Уул аймгийн здтг/

